

УЛААНБААТАР ХОТОД ШИНЭЭР БАРИГДАХ БАРИЛГА  
ОБЪЕКТОД НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР ТЕХНИКИЙН  
НӨХЦӨЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журам нь Монгол Улсын Эрчим хүчний тухай, Харилцаа холбооны тухай, Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай, Усны тухай, Газрын тухай хууль, Засгийн газрын 2012 оны 151 дүгээр тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 5/14 дугаар тогтоол, Эрчим хүчний зохицуулах хорооны 2013 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ Хувьцаат компанийн холболтын журам”, Эрчим хүчний сайдын 2013 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 03 дугаар тушаалаар батлагдсан “Цахилгаан, дулааны эрчим хүчээр хангах техникийн нөхцөл олгох журам”, Эрчим хүчний зохицуулах хорооны 2014 оны 8 дугаар тогтоолоор баталсан “Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн хүрээнд мөрдөх холболтын журам”, “Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм, Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм”, Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм, Эрчим хүчний яамны 2014 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 1/1336 дугаар албан тоот болон холбогдох дүрэм, журмуудыг тус тус мөрдлөг болгоно.

1.2.Улаанбаатар хотод барилга байгууламжыг инженерийн шугам сүлжээнд холбох иргэн хуулийн этгээдийн хүсэлтийг хүлээн авч 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг, "Шинэ бүтээн байгуулалт" хөтөлбөр болон техник технологийн шинэчлэлтэй уялдуулж тооцоо судалгааг хийж техникийн нөхцөл олгох ажлыг чирэгдэлгүй түргэн шуурхай нэг цэгийн үйлчилгээгээр олгох үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

Хоёр. Нэр томъёо

2.1.Техникийн нөхцөл олгогч гэж холбогдох хууль журмуудын дагуу заагдсан хангагч, болон түүний дээд шатны төрийн захиргааны байгууллагуудыг хэлнэ. (Эрчим хүчний яам, Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК, Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК, Мэдээлэл Холбооны Сүлжээ ТӨХХК, Ус сувгийн удирдах газар НӨҮГ, Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэл, ОНӨААТҮГ, Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ)

2.2.Иргэн хуулийн этгээдийн барилга байгууламжийг инженерийн шугам сүлжээнд холбохын тулд заавал хангах техникийн шаардлагыг тусгасан баримт бичгийг техникийн нөхцөл гэнэ.

2.3.Нэг цэгийн үйлчилгээ гэж иргэн хуулийн этгээдэд чирэгдэл сааталгүй, түргэн шуурхай үйлчлэхэд зориулж хэрэглэгчийн хүсэлтийг Хангарьд ордоны Иргэдийг хүлээн авах төв болон ОСНААУГ-ын Хэрэглэгчдэд үйлчлэх төвүүдэд хүлээн авч, техникийн нөхцөл олгогч байгууллагуудаас шаарддаг урьдчилсан тооцоо судалгааг хийж хангагч байгууллагуудад танилцуулж техникийн нөхцөл олгох, хяналт тавих үйл ажиллагааг хэлнэ.

2.4.Техникийн нөхцөл олгохтой холбоотой харилцаанд оролцогч хуулийн этгээд, өмчийн хэлбэрээс үл хамааран энэхүү журмыг дагаж мөрдөнө.

Гурав. Үйлчилгээ үзүүлэх явцын дэс дараалал

3.1. Техникийн нөхцөл олгох үйлчилгээ нь хоёр үе шаттай явагдана.

3.1.1.Нэгдүгээр үе шатанд Нийслэлийн засаг дарга газар олгох эрх олгох шийдвэр гаргахын өмнө тухайн газарт баригдах барилгын зориулалт, хэмжээг үндэслэн хангагч байгууллагын төлөөлөл орсон техникийн комисс хэлэлцэж техник технологийн шийдлийгтодорхойлно.

3.1.2.Хоёрдугаар үе шатанд архитектор төлөвлөлтийн даалгавар, эскиз зургийг батлана. Үүний дараа техникийн нөхцөлийг олгоно. Жич: (Техникийн нөхцөл хүсэгч иргэн, аж ахуйн нэгж нь төлөвлөж буй барилга объектийн байршилд байрладаг харьяа ОСНАА-н хэрэглэгчдэд үйлчлэх төвүүдэд хүсэлт гаргана.Тухайн байршил нь хэрэглэгчдэд үйлчлэх төвүүдэд харьяалагдахгүй нөхцөлд Захирагчийн ажлын албанд хүсэлтээ гаргана. Аль ч тохиолдолд доорх зүйлийг иж бүрдэл болгоно.) Үүнд:

1. Хэрэглээг тооцож, техникийн нөхцөл хүссэн өргөдөл, албан бичиг
2. Батлагдсан барилга архитектур төлөвлөлтийн даалгавар,
3. Барилгын батлагдсан эскиз зураг
4. Бусад холбогдох бичиг баримт шаардах(шаардлагатай нөхцөлд)

3.2. Хэрэглэгчдэд үйлчлэх төвүүд урьдчилсан тооцоо судалгааг боловсруулж хангагч байгууллагуудад ажлын 2 хоногийн дотор хүргэж өгнө.

3.3.Техникийн нөхцөл олгогч материалуудыг хүлээн авч техникийн нөхцөл олгох комиссын хурлыг 7 хоног бүр зохион байгуулж шийдвэрийг гаргана.

3.4. Техникийн нөхцөл олгогч техникийн нөхцөл олгох комиссын хурлын шийдвэрийг баталгаажуулж ОСНАА-н хэрэглэгчдэд үйлчлэх төвүүдэд 2 хоногийн дотор хүргэнэ.

3.5. Хэрэглэгчдэд үйлчлэх төвүүдэд ирүүлсэн техникийн нөхцөлийн баримт бичгийг төлбөр төлсөн баримтыг үндэслэж олгоно.

3.6. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны холбогдох мэргэжилтэнгүүд техникийн нөхцөл олгогч байгууллагуудын техникийн нөхцөл олгох комиссын хуралд оролцож хяналт тавьж ажиллана.

3.7. Гэр хорооллын дахин төлөвлөлтийн бүсэд техникийн нөхцөлийг томоохон хүчин чадалтайгаар олгох техникийн нөхцөл олгогчийн шийдвэрийг үндэслэн хот байгуулалтын бодлого, төлөвлөлт, өөрчлөлтүүдтэй уялдуулж техникийн нөхцөлийн хуваарилалтыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба холбогдох байгууллагуудыг оролцуулан шийдвэрлэж баталгаажуулан иргэд аж ахуйн нэгжид үйлчилнэ.

3.8. Техникийн нөхцлийн төлбөрийн хэмжээ тогтоох, ОСНАА-н ХҮТ-ийн үйлчилгээний төлбөр тооцоог гүйцэтгэх асуудлыг тухайн байгууллагын дотоод журмын дагуу шийдвэрлэнэ.

#### Дөрөв. Хүлээх үүрэг, хариуцлага

4.1. Энэхүү журмын 3.4,5,6-д заасан хугацаанд техникийн нөхцөлийг шийдвэрлээгүй тохиолдолд холбогдох албан байгууллага, албан тушаалтанд Иргэний хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

4.2 Техникийн нөхцөл хүссэн иргэд, хуулийн этгээдүүд нь техникийн нөхцөл хүсэхдээ шугам сүлжээний ачаалал, хэрэглээгээ буруу тооцсон тохиолдолд гарах хариуцлагыг техникийн нөхцөл олгогч хариуцахгүй.

4.3 Техникийн нөхцөлийг үндэслэл муутай эсвэл буруу боловсруулж олгосноос иргэн хуулийн этгээдэд учирсан шууд хохирлыг техникийн нөхцөл олгогч байгууллага хариуцна.

#### Тав. Бусад зүйлс

5.1. Улаанбаатар хотод техникийн нөхцөлийг хэрэглэгчдэд нэг цэгийн үйлчилгээгээр олгохдоо авто зам инженерийн шугам сүлжээний ашиглалтын байгууллагуудын хоорондын уялдааг хангуулах, техникийн нөхцөлийн дагуу инженерийн шугам сүлжээ барих өргөтгөн шинэчлэх зорилгоор авто зам, тохижилт, ногоон байгууламжийг сэтлэх сүвлэх үед “Авто зам, тохижилт, ногоон байгууламжийг ашиглах хамгаалах журам”-ыг хэрэгжүүлэх ажлуудыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дарга бөгөөд Ерөнхий менежер хариуцаж зохион байгуулна.

5.2. Хангагч байгууллагууд эх үүсвэрийн хүчин чадал, төв магистраль болон салаа шугамуудын нэвтрүүлэх чадварт тулгуурлан жил бүр хүчин чадлын нөөцийг тодорхойлон гаргаж, жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд хүргүүлж ажиллана.

5.3. Энэ журмаар зохицуулагдаагүй харилцааг бусад хууль, тогтоомжийн хүрээнд зохицуулна.

## ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ ОЛГОХ 1-Р ҮЕ ШАТ

Техникийн комисс



НӨХГ, НЕТГ



ОСНАА-н ХҮТ



Техникийн нөхцөл олгогч



ОСНАА-н ХҮТ

1. Тухайн газарт баригдах барилгын зориулалт, хүчин чадал (Цахилгаан эрчим хүч, Дулааны эрчим хүч, Усан хангамж Ариутгах татуурга, Холбоо) хэмжээг үндэслэн хангагч байгууллагын төлөөлөл орсон техникийн комисс хэлэлцэж техник технологийн болоцоот шийдлийг тодорхойлно.

2. Техникийн комиссын шийдвэрийг үндэслэн Нийслэлийн засаг дарга газар олгох барилга гаргах шийдвэр гаргана. Архитектор төлөвлөлтийн даалгавар, Эскиз батлагдана.

## ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ ОЛГОХ 2-Р ҮЕ ШАТ

1. Хэрэглэгчдэд үйлчлэх төвүүд /Цахилгаан түгээх, Орон сууц ХҮТ/ урьдчилсан тооцоо судалгааг боловсруулж техникийн нөхцөл олгогч байгууллагуудад 2 хоногийн дотор хүргэж өгнө.

2. Техникийн нөхцөл олгогч байгууллагууд материалуудыг хүлээн авч техникийн нөхцөл олгох комиссын хурлыг 7 хоног бүр зохион байгуулж шийдвэрийг гаргана. Хангагч байгууллага техникийн нөхцөл олгох комиссын хурлын шийдвэрийг баталгаажуулж ОСНАА-н хэрэглэгчдэд үйлчлэх төвүүдэд 2 хоногийн дотор хүргэнэ.

3. Хэрэглэгчдэд үйлчлэх төвүүдэд ирүүлсэн техникийн нөхцөлийг хангагч байгууллагын тогтоосон төлбөрийг төлсөн баримт, ОСНАА-н үйлчилгээний төлбөрийн баримтыг тус тус үндэслэж хэрэглэгчдэд олгоно.

/Жич: Тухайн байршил нь хэрэглэгчдэд үйлчлэх төвүүдэд харъяалагдахгүй нөхцөлд Захирагчийн ажлын албанд хүсэлтээ гаргана./

## АВТО ЗАМ, ТОХИЖИЛТ, НОГООН БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАХ, ХАМГААЛАХ ЖУРАМ

### Нэг.Нийтлэг үндэслэл

1.1 Нийслэл хотод шинээр Инженерийн шугам сүлжээ барих өргөтгөн шинэчлэх, засварлахаар Авто зам, тохижилт, ногоон байгууламжийг сэтлэх, сүвлэх, орц гарц гаргах ажлын зөвшөөрлийг олгох, сэргээн засварлах, түүнд шаардагдах хөрөнгийг төвлөрүүлэн зарцуулах, ажлыг чанартай технологийн дагуу хийж гүйцэтгэх, авто зам ашиглалт, нийтийн эзэмшлийн зам талбай, эд хөрөнгийг бүрэн бүтэн байлгах, тохижилт ногоон байгууламжийн ашиглалт хамгаалалтыг хангах, хяналт тавих зөрчил дутагдлыг арилгуулахад энэхүү журмын зорилго оршино.

### Хоёр. Зөвшөөрөл олгох үйл ажиллагаа

2.1 Нийслэлийн нутаг дэвсгэрт авто зам, тохижилт, ногоон байгууламжийг сэтэлж, сүвлэж инженерийн шугам сүлжээ, орц гарц гаргах, үйл ажиллагаа явуулах иргэн, аж ахуйн нэгж “Иргэд хүлээн авах төв”-д дараах бичиг баримтыг бүрдүүлж ирүүлнэ. Үүнд:

- 2.1.1. Албан бичиг, өргөдөл /иргэн/;
- 2.1.2 Ажил эхлүүлэх зөвшөөрөл /Тухайн барилгын “Барилга угсралтын ажил эхлүүлэх зөвшөөрөл” авсан барилгын ажил/;
- 2.1.3. Техникийн нөхцөл;
- 2.1.4. Шугам сүлжээний батлагдсан ажлын зураг схем;
- 2.1.5. Ажил гүйцэтгэх график, байршлын фото зураг;
- 2.1.6. Батлагдсан ерөнхий төлөвлөгөө.

2.2 “Иргэд хүлээн авах төв”-д ирсэн материалыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба хүлээн авч Нийслэлийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэгт хэлэлцүүлнэ.

2.3. Ажлын хэсэг долоо хоногт нэгээс доошгүй удаа хуралдаж, хүсэлт ирүүлсэн иргэн, байгууллагын материалыг судлан газар дээр нь үзэж танилцан шийдвэр гаргаж Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга баталгаажуулж хариу өгнө.

2.4. Авто зам, тохижилт, ногоон байгууламжийг сэтлэх, сүвлэх шугам сүлжээ татах, орц гарц гаргахдаа барилгын норм ба дүрэмд заасны дагуу нөхөн сэргээх ажлыг үе шат бүрээр мэргэжлийн байгууллагын хяналтан доор хийж гүйцэтгэнэ.

2.5. Авто зам, тохижилт, ногоон байгууламжийг сэтлэх, сүвлэх, орц гарц гаргах зайлшгүй шаардлагатай бол тухайн ажлын тоо хэмжээг гаргаж, нөхөн

сэргээх зардлыг хүсэлт гаргасан байгууллага, аж ахуйн нэгж, иргэд Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дансанд төвлөрүүлнэ.

2.6. Авто зам, тохижилт, ногоон байгууламжийг нөхөн сэргээх зардлыг замын хийц, бүтэц, хөрсний шинж чанар, нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн үнэлгээ, замын ачаалал, өдөр шөнө, амралтын цагаар ажиллах зэргийг тооцсоны үндсэн дээр үнэлгээний жишиг үнийг харгалзан Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас тогтооно.

2.7. Зөвшөөрөлд зам хаах болон нээх огноо, авто зам сэтлэх, сүвлэх ажлын хэмжээ, шугам сүлжээ татах хугацаа, нөхөн сэргээх өдөр, цагийг тодорхой тусгана.

2.8. Хөдөлгөөний нягтрал ихтэй нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажлыг хийхэд амралтын өдрүүдэд болон шөнийн цагаар хийж гүйцэтгэж болно.

2.9. Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах үүднээс Зөвшөөрөл олгосон байгууллага нь ажил явагдах замыг хаах, хөдөлгөөний зохион байгуулалтын талаар Шуурхай удирдлагын төвөөр дамжуулан холбогдох дүүрэг, нийтийн тээврийн байгууллагад, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зам, талбайг хаахаас 72 цагийн өмнө нийтэд мэдээлнэ.

2.10. Авто зам, тохижилт, ногоон байгууламжийг сэтлэх, сүвлэх, орц гарц гаргах зөвшөөрлийг тухайн оны 10 дугаар сарын 01-нээс дараа оны 4 дүгээр сарын 01-нийг хүртэл олгохыг хориглоно. Онцгой тохиолдолд /Аваарийн нөхцөл үүссэн үед/ Ерөнхий менежерийн шийдвэрээр гэмтэл, саатал арилгах зорилгоор зөвшөөрлийг олгож болно.

Гурав. Ажил гүйцэтгэх үйл ажиллагаа

3.1 Замын хөдөлгөөний аюулгүй байдал, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангах үүднээс барилгын норм ба дүрмийн дагуу шаардлагатай бэлтгэлийг хангасан байна./Хөдөлгөөн хаах механик хаалт, тэмдэг заалт, тууз гэх мэт/

3.2. Гүйцэтгэгч байгууллага нь ажил гүйцэтгэх хүн хүч, машин механизм, техник хэрэгслийг хангах ба бэлтгэл ажил хангагдаагүй тохиолдолд зам сэтлэх, сүвлэх, орц гарц гаргах ажлыг хойшлуулах, зөвшөөрлийг хүчингүй болгох арга хэмжээ авна.

3.3. Ажил гүйцэтгэх үед зөвшөөрөлд заагдсанаас бусад нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг гэмтээхгүй, бохирдуулахгүй байх бүхий л нөхцөлийг гүйцэтгэгч байгууллага бүрдүүлсэн байна.

3.4. Авто зам, тохижилт, ногоон байгууламжийн нөхөн сэргээлтийг барилгын норм ба дүрэм, техникийн шаардлагын дагуу хийж гүйцэтгэнэ.

3.5. Авто зам, тохижилт, ногоон байгууламжийн нөхөн сэргээлтийн ажлыг хариуцсан гудамж зам, талбайн заагийн дагуу ашиглалт хариуцсан байгууллага гүйцэтгэж ажиллах бөгөөд тухайн нөхцөл байдлаас хамаарч авто зам, замын байгууламж барих, засварлах тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагаар технологийн дагуу хийж гүйцэтгүүлж болно.

3.6. Авто зам, тохижилт, ногоон байгууламжийн барилгын норм ба дүрэмд заасан стандартын дагуу тогтоосон хугацаанд нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэн ашиглагч байгууллагад хүлээлгэн өгнө.

3.7. Гүйцэтгэгч нь хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангаж ажиллана.

#### Дөрөв. Хүлээлгэх хариуцлага

4.1. Авто зам, тохижилт, ногоон байгууламжийг зөвшөөрөлгүйгээр сэтэлсэн, сүвлэсэн, орц гарц гаргасан, эвдэж гэмтээсэн тохиолдолд дүүргийн олон нийтийн байцаагч, олон нийтийн цагдаагийн ажилтан хөндлөнгийн хяналт тавьж, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч, холбогдох байгууллага болон мэргэжлийн хяналтын улсын байцаагчид мэдэгдэнэ.

4.2. Зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтанд улсын байцаагч торгууль оногдуулж, нөхөн сэргээлтийн зардлыг 5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгийг төлүүлж, холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

4.3. Зөвшөөрөлд заасан хугацаанд ажлаа бүрэн хийж дуусаагүй, хугацаа хэтрүүлэх, замын хөдөлгөөнд саад учруулах, Авто замын тухай хууль болон Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хууль тогтоомжинд заасан хариуцлага ногдуулах бөгөөд үүнээс үүдэн гарах хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

4.4. Энэхүү журмын 3 дугаар зүйлийн 3.3-т заасныг зөрчиж заасан хэмжээнээс илүү зам сэтэлсэн иргэн, аж ахуйн нэгж байгууллага замын нөхөн сэргээлтийн зардлыг 3 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү хэмжээний төлбөр төлнө. Ашиглалтын явцад замд суулт өгсөн тохиолдолд нөхөн сэргээлт хийсэн байгууллага өөрийн хөрөнгөөр дахин хийж гүйцэтгэнэ.

#### Тав. Бусад

5.1. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан инженерийн шугам сүлжээний ажлын зураг, төсөвт авто зам, тохижилт, ногоон байгууламжийг нөхөн сэргээх зардлыг тусгаж өгнө.

5.2. Инженерийн шугам сүлжээний зураг төслийг мэргэжлийн байгууллагатай зөвшилцсөн байна.